

МАХН-ын Тов Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зовлолийн 1979.05.29-ний одрийн “Батлан хамгаалах хвчийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 13 тоот тогтоолоор “оператив, байлдааны болон улс төрийн бэлтгэлийн тэргүүн туршлагыг нэгтгэн дүгнэж нэвтрүүлэх, цэргийн түүх судлах зорилгоор БХЯ-ны цэргийн түүхийн болон Ардын Армийн Жанжин Штабын цэргийн эрдэм шинжилгээний тасгийг нэгтгэн “Цэргийн эрдэм шинжилгээний институт”-ыг байгуулсан.

Тус хврээлэн энэ хугацаанд 6 удаа бүтэц зохион байгуулалтын оорчлолтод орсон байна. 1990 оноос Цэргийн түүхийн хврээлэн, 1991 оноос Цэргийн Их Сургуулийн эрдэм шинжилгээний хврээлэн, 1993 оноос БХЯ-ны Эрдэм шинжилгээний хврээлэн, 1996 оноос ЦИС-ийн Цэргийн эрдэм шинжилгээний хврээлэн, 1999 оноос Батлан хамгаалахын их сургуулийн харьяа Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хврээлэн болон зохион байгуулагдсан.

Батлан хамгаалахын сайдын 2016 оны 06 дугаар сарын 14-ний одрийн А/177 дугаар тушаалаар тус хврээлэн нь Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын тов, Батлан хамгаалахын дүн шинжилгээний тов, Цэргийн урлаг судлалын тов, Байлдааны зэвсэглэл, техник, технологи судлал, инновацийн тов, Цэргийн түүх судлалын тов бүхий шинэ бүтэц, зохион байгуулалтад шилжин ажиллаж байна.